

МУИС-ийн ХБООИТ-ийн дэд профессор Н.Оюунчимэг, Газарзүйн тэнхимийн дэд профессор Д.Даваадорж нарын боловсруулсан “Тогтвортой хөгжил” хичээлийн хөтөлбөрт өгсөн санал

Улаанбаатар хот

2023.10.02

Тогтвортой хөгжил хичээлийн хөтөлбөрт багтсан хичээлийн агуулга, сэдвүүд, онолын ойлголт, ухагдахууныг МУ-ын ногоон хөгжлийн стратеги, тогтвортой хөгжлийг хангахад оновчтой ашиглах мэдлэг, чадвар, дадал, хандлага бүхий НҮБ -ын тогтвортой хөгжлийн 17 зорилтын хүрээнд тодорхойлж тэдгээрийг хэрэгжүүлэх бодлогын хэрэгжилт, олон улсын хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөрүүдийн талаар харьцуулан авч үзэж байгаа нь цаг үеийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахуйц сайн хөтөлбөр болжээ.

Түүнчлэн сэдвийн агуулга нь тогтвортой хөгжлийн бүрдэл хэсгүүдийн нарийн уялдаа холбоо, хүрээлэн буй орчны тогтвортой байдлын үндэс суурь цаашдын чиг хандлагын талаар дэлгэрэнгүй тусгаж олон улсын туршлагатай харьцуулсан нь оюутан залууст өмнөх мэдлэг, чадвараа бататгах, тогтвортой хөгжил, хүрээлэн буй орчны тогтвортой хөгжилтэй уялдуулан судлахад дөхөмтэй болсон нь сайн хичээлийн хөтөлбөр болжээ.

Харин тухайн хичээлийн хөтөлбөрийг цаашид сайжруулахдаа дараах зүйлийг анхаарч үзэх шаардлагатай гэж үзэв. Үүнд:

1. Тухайн хичээлд ашиглагдах зарим сурах бичиг, гарын авлага нь хуучирсан цөөн тооны ном материалын жагсаалт оруулсан байна. Үүнийг өөрчлөх, илүү сайжруулах боломжтой байж болох юм.

Санал бичсэн:

МУИС-ийн Инженер Технологийн Сургуулийн ХБООИТ-ийн
дэд профессор, доктор (Ph.D) *Д. Батсүрэн* Д.Батсүрэн